



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 09 сарын 14 өдөр

Дугаар A/541

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/a/, 29.2, Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар ард түмний бүрэн эрхт байдал, оролцоог хангах тухай” 39 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг орон нутгийн хэмжээнд иргэдээр хэлэлцүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 3901000 /Гурван сая есөн зуун нэг мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны
09 дүгээр сарын 15-ны өдрийн
571 дугаар захирамжийн хавсралт

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг
орон нутгийн хэмжээнд иргэдээр хэлэлцүүлэх ажлыг зохион
байгуулахад шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг-өөр/	Нийт дүн /төг-өөр/	Тайлбар
1	Сургалт хэлэлцүүлгийн цайны зардал	710	1900	1 349 000	
2	Хэлэлцүүлэгт оролцох албаны хүмүүсийн хоолны зардал	16x13200x5	13200	1056000	
3	Улаанбаатараас ирэх төлөөлөгчдийн буудлын зардал			1 496 000	
	НИЙТ			3 901 000	

000